

Зөвлөмж-Хурдан морь унаач хүүхдийн даатгал

Жил бүрийн энэ цаг үед иргэд, наадамчин олон хүчит бөх, хурдан морь, цэц мэргэнээ сорихоор Үндэсний баяр наадамдаа бэлтгэн хүлээдэг уламжлалтай.

Үүнтэй холбоотой хурдан морь унаач хүүхдийг морин уралдаан, бэлтгэл сунгааны үеэр учирч болзошгүй эрсдэлээс даатгаж, эрсдэлийн улмаас учрах санхүүгийн хохирлоос хамгаалах зорилго бүхий даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг даатгалын компаниудаас боловсруулан Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж байна.

Тус Хороонд “МИГ даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Мөнх даатгал” ХХК гэсэн арван компани дээрх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хянуулж, бүртгүүлээд байна.

Хурдан морь унаач хүүхдийн даатгалтай холбоотой иргэд, даатгуулагчдад дараах зөвлөмжийг хүргэж байна.

Даатгалын гэрээгээ сайтар судлаарай!

1. Даатгалын компани тань “Хурдан морь унаач хүүхдийн даатгал”-аа Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн эсэхийг шалгаж лавлаарай.
2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.6 дугаар зүйлийн 10.6.4 дэх хэсэгт “хүүхдийг ослын даатгалд даатгуулсан байх;” гэж заасан тул үндэсний баяр наадмын хурдан морь унаач хүүхдийг албан журмаар даатгалд хамруулахаар байна.
3. Даатгуулагч нь хурдан морь унаач хүүхдийн эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгч байх шаардлагатай. Хууль ёсны төлөөлөгч гэдэгт Иргэний хуулийн 17 дугаар зүйлд заасан эцэг эх, асран хамгаалагчийг хамааруулна.
4. Даатгалын компани нь Таныг даатгалын сонголт хийх боломжоор хангах үүрэгтэй бөгөөд иргэн Таны хувьд даатгалын гэрээний онцлог, нөхцөл, давуу тал, хураамжийн хэмжээг харгалзан сонголт хийх эрхтэй.
5. Даатгалын үнэлгээгээ даатгагчтайгаа харилцан тохиролцож тодорхойлох бол даатгалын хураамж нь даатгалын үнэлгээ, компанийн актуар тооцооллоос хамаарч тооцогдоно. Мөн даатгалд хамаарахгүй нөхцөлүүд, нөхөн төлбөр олгох хугацаа, даатгалын тохиолдол үүсэхэд бүрдүүлэх баримт бичиг зэрэгтэй сайтар танилцаж, харьцуулж, асууж, зөвлөгөө аваарай.
6. Зарим даатгал нь зөвхөн Үндэсний баяр наадмын хурдан морины уралдаанд оролцох үеийн эрсдэлээс даатгах бол зарим бүтээгдэхүүний хувьд бүсийн болон орон нутгийн чанартай уралдаан тэмцээн, эсхүл жилийн хугацаанд гэнэтийн осол, аюул эрсдэлээс даатгах боломжтой байх тул даатгуулагч сонголт хийх боломжтойг анхаарна уу.
7. Даатгалын тохиолдол гарсан бол нэн даруй даатгалын компанидаа мэдэгдэх Таны үүрэг гэрээнд туссан байгаа. Мөн Даатгалын хохирол үнэлгээний зардлыг хэн хэрхэн төлөх талаар асууж тодруулахыг Бид зөвлөж байна.